**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement.bayankhongor@audit.gov.mn

2025.02.25 № 1/226

танай ____________ -ны № ____________ -т

БАЯНГОВЬ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ш.УРАНЧИМЭГ ТАНАА

Тус байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайланг хүргүүлж байна.

Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилийг 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Хавсралт 22 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

006425030392

[illegible]
[illegible]
ᠤᠲᠠᠰᠤ : (976) 70442584
ᠢᠮᠸᠯ ᠬᠠᠶᠢᠭ :
procurement.bayankhongor@audit.gov.m
ᠪᠠᠶᠠᠨᠬᠣᠩᠭᠤᠷ ᠰᠤᠮᠤ · 64101
[illegible] 1 [illegible]
310 [illegible] 3

[illegible] 2024-02-08 [illegible]

[illegible] ___ ᠤ ___ ᠰᠠᠷ᠎ᠠ ___

[illegible]

[illegible] 2025 ᠣᠨ ᠤ 05 ᠰᠠᠷ᠎ᠠ [illegible]

[illegible] 2024 ᠣᠨ ᠤ [illegible]

[illegible] 20 [illegible]

6425030384

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Баянговь  сумын ерөнхий боловсролын сургуулийн  2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** БНА-2025/019/НА-СТА-ТШ3

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2025 оны 02 дугаар сар 23


Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас: 70442584  Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер  М.Алтантуяа
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Номгон аудит ХХК
Захирал Г.Саранчимэг
Утас: 89891034 Цахим хаяг: audit.nomgon @gmail.com
Аудитор::                    О.Мандах
Утас: 89010203          Цахим хаяг: audit.nomgon@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ....3
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**....9
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ....16
**4. АУДИТЫН ТАЙЛАН**....19
**4.1 Ерөнхий зүйл**....19
**4.2 Материаллаг байдал** ....19
**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ....19
**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**..19
**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**....19
**4.5 Худалдан авах ажиллагааны талаар** ....20
**4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ....20
**4.6.1 Завсрын аудитын талаар** ....20
**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**....20
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ....21
**5.1.1 Албан шаардлага** ....21
**5.1.2 Төлбөрийн акт** ....21
**6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**....22

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| БШУС | Боловсрол, шинжлэх ухааны сайд |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| СТСХ | Санхүү, төрийн сангийн хэлтэс |
| НБББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2025.02.25 № 2/76

танай____________-ны № _____________ -т

БАЯНГОВЬ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ш.УРАНЧИМЭГ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баацагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Баянговь сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн бараа материал бүлгийн тусгай зориулалтын материал, бичиг хэргийн материал, аж ахуйн материал, түлш шатахуун, барилгын засварын материал, бусад хангамж дансны 2024 оны 07 дугаар сарын 01-нээс 12 дугаар сарын 31 дуусталх анхан шатны баримт, тайлан ирүүлээгүйгээс бараа материалын тайлан дах орлогын 44.512.0 мянган төгрөг зарлагын 32.039.1 мянган төгрөгийн бараа материалын гүйлгээг тус тус нотлох боломжгүй байгаа нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дэх "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа

5020366

эсэхийг хянах", 20.2.6 дэх "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" үнэн зөв байх, бодитой оршин байх  гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2024 онд **2,122,587.2** мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 1,879,511.8  мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 1,358.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж, нийт 243,075.4 мянган төгрөгийн мөнгө хөрөнгийн үлдэгдэлтэй гарчээ.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх бөгөөд Баянговь  сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын 76 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 96 хувьтай тайлагнасныг 90.19 хувьтай дээд шатны байгууллагаас дүгнэсэн  байна.

Баянговь  сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠦᠨᠳᠦᠰᠦᠨ ᠦ ᠠᠦ᠋ᠳᠢᠲ ᠤᠨ ᠭᠠᠵᠠᠷ
ᠪᠠᠶᠠᠨᠬᠣᠩᠭᠣᠷ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠤᠨ ᠠᠦ᠋ᠳᠢᠲ ᠤᠨ ᠭᠠᠵᠠᠷ

[illegible] : procurement.bayankhongor@audit.gov.mn
[illegible] 64101 , [illegible]: (976) 70442584
[illegible] 1 [illegible]
310 [illegible] 3

2024-02-22 № 1/26

[illegible] № [illegible]

[illegible]

[illegible]

[illegible] 6 [illegible] 6.3.1, 8 [illegible] 8.1, [illegible] 8 [illegible] 8.9.1 [illegible] 2024 [illegible] 12 [illegible] 31 [illegible]

[illegible] 2024 [illegible] 12 [illegible] 31-[illegible]

[illegible]

[illegible]

2024 [illegible] 2024 [illegible] 07 [illegible] 01-[illegible] 12 [illegible] 31 [illegible] 44.512.0 [illegible] 32.039.1 [illegible]

0024350202.84

ᠠᠦᠳᠢᠲ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠢ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ 20 ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ 20.2.3 ᠳᠤ «ᠰᠠᠩᠬᠦᠦ ᠶᠢᠨ ᠲᠠᠶᠢᠯᠠᠩ ᠢ ᠬᠢᠨᠠᠨ ᠪᠠᠲᠤᠯᠠᠬᠤ» ᠭᠡᠵᠦ ᠵᠢᠭᠠᠭᠰᠠᠨ ᠤ ᠳᠠᠭᠠᠤ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠲᠤᠰᠢᠶᠠᠯ ᠤᠨ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠯᠭ᠎ᠠ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠬᠤ ᠠᠯᠪᠠᠨ ᠲᠤᠰᠢᠶᠠᠯ ᠤᠨ ᠪᠠᠶᠢᠳᠠᠯ ᠢ ᠲᠣᠳᠣᠷᠬᠠᠶᠢᠯᠠᠨ᠂ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠯᠭ᠎ᠠ᠂ ᠲᠠᠶᠢᠯᠠᠩ᠂ ᠠᠯᠪᠠᠨ ᠲᠤᠰᠢᠶᠠᠯ ᠤᠨ 9 ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠡᠷᠬᠡ ᠦᠦᠷᠡᠭ ᠢ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠦᠯᠲᠡ ᠶᠢ ᠬᠢᠨᠠᠨ ᠪᠠᠲᠤᠯᠠᠬᠤ ᠬᠦᠷᠲᠡᠭᠡᠯ ᠦᠨ ᠰᠠᠩᠬᠦᠦ ᠶᠢᠨ ᠲᠠᠶᠢᠯᠠᠩ᠋» 20.2.4 "ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠲᠤᠰᠢᠶᠠᠯ ᠤᠨ ᠵᠣᠬᠢᠰᠲᠠᠢ ᠦᠢᠯ᠎ᠡ ᠠᠵᠢᠯᠯᠠᠭᠠ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠳᠦ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠬᠢᠬᠦ" ᠬᠣᠶᠠᠷ᠂ ᠹ᠂᠂ 20.2.6 ᠳᠤ «ᠲᠡ ᠬᠣᠶᠠᠷ ᠤᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠰᠠᠩᠬᠦᠦ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠯᠭ᠎ᠠ ᠶᠢ ᠲᠣᠳᠣᠷᠬᠠᠶᠢᠯᠠᠬᠤ᠂ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ᠂ ᠲᠠᠶᠢᠯᠠᠩ ᠢ ᠬᠢᠨᠠᠨ ᠪᠠᠲᠤᠯᠠᠬᠤ᠂ ᠦᠨᠡᠯᠡᠬᠦ᠂ ᠪᠠᠲᠠᠯᠭᠠᠵᠢᠭᠤᠯᠬᠤ᠂ ᠲᠤᠰ ᠬᠦᠷᠦᠩᠭᠡ ᠶᠢᠨ ᠠᠰᠢᠭ ᠲᠤᠰᠢᠶᠠᠯ ᠤᠨ ᠪᠠᠶᠢᠳᠠᠯ᠂ ᠬᠢᠷᠢ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠶᠢ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠬᠤ᠂ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠦᠢᠯ᠎ᠡ ᠠᠵᠢᠯᠯᠠᠭᠠᠨ ᠤ ᠪᠠᠶᠢᠳᠠᠯ ᠢ ᠦᠨᠡᠯᠡᠬᠦ᠂ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠯᠭ᠎ᠠ» ᠭᠡᠵᠦ ᠲᠤᠰ ᠲᠤᠰ ᠪᠦᠷ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠪᠦᠷᠢᠨ ᠡᠷᠬᠡ ᠢ ᠲᠤᠭᠠᠳᠤᠭᠰᠠᠨ ᠪᠠᠶᠢᠨ᠎ᠠ ::

ᠰᠠᠩᠬᠦᠦ ᠶᠢᠨ ᠲᠠᠶᠢᠯᠠᠩ ᠤᠨ ᠲᠣᠳᠣᠷᠬᠠᠶᠢᠯᠠᠯᠲᠠ

ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠰᠠᠩᠬᠦᠦ ᠶᠢᠨ ᠲᠠᠶᠢᠯᠠᠩ ᠢ ᠠᠵᠢᠯ ᠤᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠦᠯᠲᠡ ᠶᠢᠨ ᠲᠦᠯᠬᠢᠭᠦᠷ ᠪᠠᠷ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠲᠤᠰᠢᠶᠠᠯ ᠤᠨ ᠪᠠᠶᠢᠳᠠᠯ ᠪᠠᠷ ᠭᠠᠷᠭᠠᠭᠰᠠᠨ ᠪᠠᠶᠢᠨ᠎ᠠ :: ᠰᠠᠩᠬᠦᠦ ᠶᠢᠨ ᠪᠠᠶᠢᠳᠠᠯ ᠤᠨ ᠲᠠᠶᠢᠯᠠᠩ ᠳᠤ ᠲᠤᠰᠬᠠᠭᠰᠠᠨ ᠬᠦᠷᠦᠩᠭᠡ᠂ ᠡᠷᠬᠡ ᠣᠯᠭᠤᠭᠰᠠᠨ ᠬᠦᠷᠦᠩᠭᠡ ᠶᠢᠨ ᠪᠠᠶᠢᠳᠠᠯ ᠢ ᠲᠣᠳᠣᠷᠬᠠᠶᠢᠯᠠᠨ ᠬᠦᠷᠦᠩᠭᠡ ᠶᠢᠨ ᠣᠷᠣᠯᠭ᠎ᠠ ᠶᠢ ᠲᠤᠰᠬᠠᠨ ᠲᠠᠶᠢᠯᠠᠩ ᠳᠤ ᠲᠤᠰᠬᠠᠭᠰᠠᠨ ᠪᠠᠶᠢᠨ᠎ᠠ ::

ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠨᠡᠶᠢᠲᠡ ᠬᠦᠷᠦᠩᠭᠡ ᠪᠠᠷ ᠰᠠᠩᠬᠦᠦᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠲᠤᠰᠤᠯ ᠤᠨ ᠣᠷᠣᠯᠭ᠎ᠠ ᠶᠢ ᠬᠦᠷᠦᠩᠭᠡ ᠶᠢᠨ ᠵᠠᠷᠤᠯᠳᠠ 2024 ᠣᠨ ᠳᠤ 2,122,587.2 ᠮᠢᠩᠭᠠᠨ ᠲᠥᠭᠦᠷᠢᠭ ᠤᠨ ᠬᠦᠷᠦᠩᠭᠡ ᠣᠷᠣᠯᠭ᠎ᠠ ᠲᠤᠰᠬᠠᠭᠳᠠᠭᠰᠠᠨ ᠤᠨ ᠳᠣᠲᠣᠷ᠎ᠠ ᠲᠦᠭ 1,879,511.8 ᠮᠢᠩᠭᠠᠨ ᠲᠥᠭᠦᠷᠢᠭ ᠢ ᠰᠠᠩᠬᠦᠦᠵᠢᠭᠦᠯᠦᠯᠲᠡ᠂ ᠪᠤᠰᠤᠳ ᠣᠷᠣᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠳᠦᠩ ᠪᠡᠷ 1,358.5 ᠮᠢᠩᠭᠠᠨ ᠲᠥᠭᠦᠷᠢᠭ ᠢ ᠬᠦᠷᠦᠩᠭᠡ ᠣᠷᠣᠯᠭᠠᠪᠣᠯᠪᠠ᠂ ᠵᠠᠷᠤᠯᠳᠠ 243,075.4 ᠮᠢᠩᠭᠠᠨ ᠲᠥᠭᠦᠷᠢᠭ ᠤᠨ ᠬᠦᠷᠦᠩᠭᠡ ᠤᠯᠠᠭᠰᠠᠨ ᠲᠤᠰᠬᠠᠭᠳᠠᠭᠰᠠᠨ ᠪᠠᠶᠢᠨ᠎ᠠ ::

ᠬᠠᠳᠠᠭᠠᠯᠠᠬᠤ ᠶᠢᠨ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠮᠡᠳᠡᠬᠦ

ᠬᠠᠳᠠᠭᠠᠯᠠᠬᠤ ᠶᠢᠨ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠶᠢ ᠮᠡᠳᠡᠬᠦ ᠳᠦ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠲᠤᠰᠢᠶᠠᠯ ᠤᠨ ᠪᠠᠶᠢᠳᠠᠯ ᠪᠠ ᠬᠠᠳᠠᠭᠠᠯᠠᠬᠤ ᠬᠦᠷᠦᠩᠭᠡ ᠶᠢᠨ ᠲᠠᠶᠢᠯᠠᠩ ᠢ ᠪᠦᠷᠲᠦᠭᠡᠯ ᠦᠨ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠡᠰᠡᠭ ᠲᠦ ᠣᠷᠣᠭᠤᠯᠵᠤ ᠬᠢᠨᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠰᠡᠨ ᠪᠠᠶᠢᠨ᠎ᠠ :: ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠶᠢ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠲᠤᠰᠢᠶᠠᠯ ᠪᠠ ᠬᠠᠳᠠᠭᠠᠯᠠᠬᠤ ᠶᠢᠨ ᠬᠦᠷᠦᠩᠭᠡ ᠳᠦ ᠪᠦᠷᠲᠦᠭᠡᠯ ᠳᠦ ᠢ ᠲᠤᠭᠠᠴᠠᠭᠰᠠᠨ᠂ ᠬᠠᠳᠠᠭᠠᠯᠠᠬᠤ ᠶᠢᠨ ᠠᠮᠤᠷ ᠲᠦᠪᠰᠢᠨ ᠪᠠᠷ ᠬᠡᠮᠵᠢᠭᠳᠡᠬᠦ ᠪᠦᠷᠲᠦᠭᠡᠯ ᠦᠨ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠡᠰᠡᠭ ᠦᠨ ᠠᠮᠤᠷ ᠬᠠᠳᠠᠭᠠᠯᠠᠬᠤ ᠶᠢᠨ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠪᠠᠶᠢᠭ᠎ᠠ ᠡᠰᠡᠬᠦ ᠶᠢ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠬᠤ ᠪᠠᠷ ᠮᠡᠳᠡᠭᠰᠡᠨ ᠪᠠᠶᠢᠨ᠎ᠠ ::

ᠪᠦᠷᠲᠦᠭᠡᠯ ᠦᠨ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ

ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠰᠠᠩᠬᠦᠦ ᠶᠢᠨ ᠪᠦᠷᠲᠦᠭᠡᠯ ᠢ ᠬᠦᠷᠦᠩᠭᠡ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠯᠭ᠎ᠠ ᠪᠡᠷ ᠬᠢᠵᠦ ᠪᠠᠶᠢᠨ᠎ᠠ :: ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠡᠳ ᠬᠦᠷᠦᠩᠭᠡ ᠶᠢᠨ ᠪᠦᠷᠲᠦᠭᠡᠯ ᠳᠦ 7 ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ 76 ᠨᠡᠷ ᠡ ᠲᠥᠷᠦᠯ ᠦᠨ ᠬᠦᠷᠦᠩᠭᠡ ᠪᠠᠷ ᠪᠦᠷᠲᠦᠭᠡᠭᠳᠡᠭᠰᠡᠨ᠂ ᠪᠦᠷᠲᠦᠭᠡᠯ ᠦᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠳᠦ ᠪᠦᠷᠲᠦᠭᠡᠭᠰᠡᠨ 96 ᠨᠡᠷ ᠡ ᠲᠥᠷᠦᠯ ᠦᠨ ᠬᠠᠳᠠᠭᠠᠯᠠᠭᠰᠠᠨ ᠪᠠᠶᠢᠨ᠎ᠠ ::

ᠬᠠᠳᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠲᠤᠰᠢᠶᠠᠯ ᠤᠨ ᠪᠦᠷᠲᠦᠭᠡᠯ ᠲᠤᠰ ᠬᠦᠷᠦᠩᠭᠡ ᠪᠠ ᠠᠯᠪᠠᠨ ᠲᠤᠰᠢᠶᠠᠯ᠂ ᠪᠦᠷᠲᠦᠭᠡᠯ ᠦᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠳᠦ ᠪᠦᠷᠲᠦᠭᠡᠭᠰᠡᠨ ᠪᠦᠷᠢᠨ ᠬᠦᠷᠦᠩᠭᠡ ᠶᠢ ᠪᠦᠷᠲᠦᠭᠡᠭᠰᠡᠨ :: ᠪᠠᠶᠢᠷᠢᠰᠢᠯ ᠳᠦ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠬᠢᠵᠦ ᠬᠠᠮᠢᠶᠠᠷᠤᠯᠤᠭᠳᠠᠬᠤ ᠲᠤᠰ ᠬᠠᠮᠢᠶᠠᠷᠤᠯᠢ ᠪᠠᠶᠢᠨ᠎ᠠ ::

**ᠠᠵᠢᠯ ᠤᠨ ᠪᠠᠶᠢᠷ᠎ᠠ ᠳᠤ ᠪᠠᠶᠢᠭ᠎ᠠ ᠬᠦᠷᠦᠩᠭᠡ ᠶᠢᠨ ᠪᠦᠷᠲᠦᠭᠡᠯ ᠬᠠᠶᠢᠭ᠂ ᠰᠢᠯᠵᠢᠯᠲᠡ**

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **205,532,599.94** | **346,547,805.83** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 118,579,225.93 | 243,075,424.02 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 118,579,225.93 | 243,075,424.02 |
| **3121** | **Төгрөг** | 118,579,225.93 | 243,075,424.02 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 118,579,225.93 | 243,075,424.02 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 86,953,374.01 | 103,472,381.81 |
| **351** | **Түүхий эд материал** | 22,613,411.40 | 27,382,207.20 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 22,613,411.40 | 27,382,207.20 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 237,700.00 | 20,700.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 64,102,262.61 | 76,069,474.61 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,229,000.00 | 1,115,340.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 59,997,434.61 | 71,656,734.61 |
| 35460 | Хүнсний материал | 201,430.00 | 00.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 2,674,398.00 | 3,297,400.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,508,126,226.11** | **2,155,247,313.91** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,508,126,226.11 | 2,155,247,313.91 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,481,750,226.11 | 2,128,871,313.91 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,401,982,608.47 | 1,969,444,417.47 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -149,997,438.80 | -195,986,753.46 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 303,658,653.07 | 353,560,984.77 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -201,203,211.85 | -164,328,070.68 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 185,945,515.11 | 216,950,518.11 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -104,114,348.76 | -128,565,586.35 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 38,735,903.98 | 77,735,903.98 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -17,072,092.32 | -24,754,737.14 |
| 39217 | Ном | 23,814,637.21 | 24,814,637.21 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 26,376,000.00 | 26,376,000.00 |
| 39301 | Програм хангамж | 450,000.00 | 450,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -450,000.00 | -450,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 26,376,000.00 | 26,376,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,713,658,826.05** | **2,501,795,119.74** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **1,192,030.28** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 1,192,030.28 |
| **413** | **Өглөг** | 00.00 | 1,192,030.28 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 00.00 | 1,163,030.28 |
| **4136** | **Бусад өглөг** | 00.00 | 29,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 00.00 | 29,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,713,658,826.05** | **2,500,603,089.46** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,713,658,826.05 | 2,500,603,089.46 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 319,214,873.32 | 319,214,873.32 |
| 51101 | Өмч: - төрийн | 319,214,873.32 | 319,214,873.32 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 493,607,342.01 | 1,280,551,605.42 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 493,607,342.01 | 493,607,342.01 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 786,944,263.41 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 900,836,610.72 | 900,836,610.72 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,713,658,826.05** | **2,501,795,119.74** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан** /Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,677,772,763.00** | **2,705,887,234.50** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **271,384,463.00** | **731,756,634.50** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 271,384,463.00 | 731,756,634.50 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 4,653,421.00 | 1,883,660.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 318,300.00 | 00.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,335,121.00 | 1,883,660.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,406,388,300.00** | **1,974,130,600.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,281,756,600.00 | 1,827,557,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,281,756,600.00 | 1,827,557,600.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 124,631,700.00 | 146,573,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 124,631,700.00 | 146,573,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,413,403,511.12** | **1,918,942,971.09** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,413,403,511.12** | **1,918,942,971.09** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,318,398,264.49 | 1,825,036,813.80 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 879,319,074.76 | 1,248,547,521.00 |
| 210101 | Үндсэн цалин | 602,667,187.56 | 753,491,855.00 |
| 210102 | Нэмэгдэл | 231,833,780.20 | 417,864,266.00 |
| 210104 | Урамшуулал | 44,818,107.00 | 77,191,400.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 110,811,570.91 | 157,430,461.07 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 74,951,440.85 | 107,446,671.65 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,997,379.03 | 12,501,068.65 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,148,739.84 | 6,250,535.25 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,719,329.19 | 6,246,439.30 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 17,994,682.00 | 24,985,746.22 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 120,174,284.37 | 142,214,442.71 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,431,268.37 | 9,141,226.71 |
| 210302 | Түлш, халаалт | 113,743,016.00 | 131,753,216.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 1,320,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,695,540.00 | 13,485,290.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,695,540.00 | 9,279,990.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 00.00 | 4,176,300.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 74,499,650.00 | 83,477,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 74,499,650.00 | 77,848,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 5,629,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,254,000.00 | 3,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,254,000.00 | 3,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,323,633.52 | 275,322.57 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 858,300.00 | 275,322.57 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,465,333.52 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 122,320,510.93 | 176,606,776.45 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 38,084,610.00 | 41,018,716.55 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 338,415.00 | 19,527,716.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 83,897,485.93 | 116,060,343.90 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 95,005,246.63 | 93,906,157.29 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 92,547,831.00 | 92,547,600.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 270,373.00 | 00.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 62,018,700.00 | 64,441,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 30,258,758.00 | 28,106,100.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 2,457,415.63 | 1,358,557.29 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,457,415.63 | 1,358,557.29 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **264,369,251.88** | **786,944,263.41** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 35,000,000.00 | 00.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 35,000,000.00 | 00.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 4 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -35,000,000.00 | 00.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **229,369,251.88** | **786,944,263.41** |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,411,041,721.00** | **1,976,014,260.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **4,653,421.00** | **1,883,660.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 4,653,421.00 | 1,883,660.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 4,653,421.00 | 1,883,660.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 318,300.00 | 00.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,335,121.00 | 1,883,660.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,406,388,300.00** | **1,974,130,600.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,281,756,600.00 | 1,827,557,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,281,756,600.00 | 1,827,557,600.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 124,631,700.00 | 146,573,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 124,631,700.00 | 146,573,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,328,522,708.19** | **1,797,527,042.91** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,328,522,708.19** | **1,797,527,042.91** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,232,381,423.56** | **1,703,837,885.62** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 875,074,756.76 | 1,253,661,324.60 |
| 210101 | Үндсэн цалин | 598,422,869.56 | 798,526,255.80 |
| 210102 | Нэмэгдэл | 231,833,780.20 | 378,695,972.00 |
| 210104 | Урамшуулал | 44,818,107.00 | 76,439,096.80 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 110,811,570.91 | 151,153,627.19 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 74,951,440.85 | 102,299,742.31 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,997,379.03 | 12,000,446.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,148,739.84 | 6,000,225.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,719,329.19 | 5,996,124.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 17,994,682.00 | 24,857,089.88 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 120,174,284.37 | 142,214,442.71 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,431,268.37 | 9,141,226.71 |
| 210302 | Түлш, халаалт | 113,743,016.00 | 131,753,216.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 1,320,000.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | 72,977,430.00 | 77,646,570.00 |
| 210502 | Хоол, хүнс | 72,977,430.00 | 77,646,570.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,000,000.00 | 3,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,000,000.00 | 3,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,207,633.52 | 18,756,821.12 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 318,300.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,889,333.52 | 18,756,821.12 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 46,135,748.00 | 57,405,100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 34,574,548.00 | 44,295,600.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,561,200.00 | 13,109,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **96,141,284.63** | **93,689,157.29** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 93,683,869.00 | 92,330,600.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 466,549.00 | 00.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 63,153,420.00 | 64,224,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 30,063,900.00 | 28,106,100.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 2,457,415.63 | 1,358,557.29 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,457,415.63 | 1,358,557.29 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **82,519,012.81** | **178,487,217.09** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **48,976,780.00** | **53,991,019.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **48,976,780.00** | **53,991,019.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 48,976,780.00 | 53,991,019.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 48,976,780.00 | 53,991,019.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-48,976,780.00** | **-53,991,019.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 33,542,232.81 | 124,496,198.09 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 85,036,993.12 | 118,579,225.93 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 117,019,225.93 | 243,075,424.02 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **319,214,873.32** | **900,836,610.72** | **493,607,342.01** | **1,713,658,826.05** |
| D01 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **319,214,873.32** | **900,836,610.72** | **493,607,342.01** | **1,713,658,826.05** |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **319,214,873.32** | **900,836,610.72** | **493,607,342.01** | **1,713,658,826.05** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 786,944,263.41 | 786,944,263.41 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **319,214,873.32** | **900,836,610.72** | **1,280,551,605.42** | **2,500,603,089.46** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан** /төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | 118,579,225.93 | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,979,447,300.00 | 1,850,159,504.62 | 241,824,738.09 | 87.6% |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,979,447,300.00 | 1,850,159,504.62 | 241,824,738.09 | 87.6% |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,848,432,900.00 | 1,612,614,461.91 | 235,818,438.09 | 87.2% |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,416,596,600.00 | 1,253,428,331.60 | 163,168,268.40 | 88.5% |
| 210101 | Үндсэн цалин | 900,472,100.00 | 800,538,403.80 | 99,933,696.20 | 88.9% |
| 210102 | Нэмэгдэл | 455,862,500.00 | 376,450,831.00 | 79,411,669.00 | 82.6% |
| 210104 | Урамшуулал | 60,262,000.00 | 76,439,096.80 | -16,177,096.80 | 126.8% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 177,074,600.00 | 151,386,620.19 | 25,687,979.81 | 85.5% |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 120,410,800.00 | 102,299,742.31 | 18,111,057.69 | 85.0% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 14,166,000.00 | 12,000,446.00 | 2,165,554.00 | 84.7% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,082,900.00 | 6,000,225.00 | 1,082,675.00 | 84.7% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 7,082,900.00 | 5,996,124.00 | 1,086,776.00 | 84.7% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 28,332,000.00 | 25,090,082.88 | 3,241,917.12 | 88.6% |
| 210300 | **Байр ашиглалттай** | 146,573,000.00 | 145,214,442.71 | 1,358,557.29 | 99% |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **холбоотой зардал** | | | | |
| 210301 | Гэрэл цахилгаан | 8,500,000.00 | 9,141,226.71 | -641,226.71 | 107% |
| 210302 | Түлш халаалт | 133,753,000.00 | 131,753,216.00 | 1,999,784.00 | 98.5% |
| 210303 | Цэвэр бохир ус | 1,320,000.00 | 1,320,000.00 | | 100% |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 3000,000.00 | | 100% |
| **2105** | **Нормативт зардал** | 110,568,400.00 | 77,646,570.00 | 32,921,830.00 | 70.2% |
| 210502 | Хоол, хүнс | 110,568,400.00 | 77,646,570.00 | 32,921,830.00 | 70.2% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 33,121,300.00 | 29,296,821.12 | 3,824,478.88 | 88.5% |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 33,121,300.00 | 29,296,821.12 | 3,824,478.88 | 88.5% |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 111072000.00 | 100856119.00 | 10,215,881.00 | 90.8% |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 97,924,300.00 | 87,746,619.00 | 10,177,681.00 | 89.6% |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 13,147,700.00 | 13,109,500.00 | 38,200.00 | 99.7% |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 98336900.00 | 92330600.00 | 6,006,300.00 | 93.9% |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 98,336,900.00 | 92,330,600.00 | 6,006,300.00 | 93.9% |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 70,230,800.00 | 64,224,500.00 | 6,006,300.00 | 91.4% |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 28,106,100.00 | 28,106,100.00 | 0.00 | 100.0% |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,979,447,300.00 | 1,850,159,504.62 | 3,433,040.00 | 99.8% |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,830,800,700.00 | 1,827,557,600.00 | 3,243,100.00 | 99.8% |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,830,800,700.00 | 1,827,557,600.00 | 3,243,100.00 | 99.8% |
| | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 146,573,000.00 | 146,573,000.00 | | |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 2,073,600.00 | 1,883,660.00 | 189,940.00 | 90.8% |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,073,600.00 | 1,883,660.00 | 189,940.00 | 90.8% |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 118,579,225.93 | | - 118,579,225.93 | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 243,075,424.02 | - 243,075,424.02 | |
| **65** | **ОРОН ТООНЫ** | **49.00** | **49.00** | | |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | МЭДЭЭЛЭЛ | | | | |
|---|---|---|---|---|---|

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд тодорхойлсон "Суралцагчийг бие даан сурч, амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэнийг төлөвшүүлэхэд оршино" гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургууль нь Боловсрол, шинжлэх ухааны яамнаас жил бүр дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу Захирлын 2024 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн А/48 дугаар тушаалаар Захиргаа аж ахуй, Сургалтын алба гэсэн бүтэц зохион байгуулалттай 49 орон тоотой, 484 суралцагчтай үйл ажиллагаа явуулсан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Бага, дунд боловсролын тухай, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн "Журам батлах тухай " 25 дугаар тогтоолын хавсралт" Боловсролын байгууллагын үйл ажиллагааны олон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам"
- Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн "Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр журам батлах тухай" 39 дүгээр тогтоол
- Засгийн газрын 2024 оны 2 дугаар сарын 28-ний өдрийн "Тогтоолд хавсралт нэмэх,тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай 84, "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 128 дугаар тогтоол.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлант онд Боловсролын ерөнхий газар болон аймгийн Боловсролын газраас хяналт, шинжилгээ, дотоод аудитын шалгалт хийгдээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,УСНББОУС-1 ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 788,136.3 мянган төгрөгөөр буюу 4.6 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 118,579.2 | 243,075.4 | 124,496.2 |
| Бараа материал | 86,953.4 | 103,472.4 | 16,519.0 |
| Үндсэн хөрөнгө | 1,980,963.3 | 2,669,332.4 | 688,369.1 |
| Хуримтлагдсан элэгдэл | -472,837.1 | -514,085.1 | -41,248.0 |
| **Нийт хөрөнгө** | **1,713,658.8** | **2,501,795.1** | 788,136.3 |
| Өр төлбөр | | 1,192.0 | 1,192.0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | **1,713,658.8** | **2,500,603.1** | 786,944.3 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,713,658.8** | **2,501,795.1** | 788,136.3 |

*Эх сурвалж: Баянговь сумын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан*

Дээрх хүснэгтээс харахад Баянговь сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь бараа материал, мөнгөн хөрөнгө ,үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант онд оны эхэнд 118,579.2 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй оны эцэст 243,075.4 мянган төгрөг өмнөх оноос 124,496.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь гүйцэтгэлээр санхүүжиж байгаатай холбоотойгоор хүүхдийн тооноос хамаарч төсөв батлагдсан ба гүйцэтгэлээр зарцуулагдсан төсвөөс хэмнэлт үүссэнээр мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өссөн байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 190,565.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, бараа материалын үлдэгдэл 16,519.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 53,991.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, Боловсролын ерөнхий газраас 49,435.6 мянган төгрөгийн хөрөнгийг машин тоног төхөөрөмжийн дансанд, Баянхонгор аймгийн ИТХ-ын даргын 2024 оны 11 дүгээр сарын 18-ний өдрийн "Үндсэн хөрөнгөнд эзэмшигч тогтоох тухай" А/99 дугаар захирамжаар 567,461.8 мянган төгрөгийн спорт заалны барилгын засварыг барилга байгууламжийн дансанд үнэ төлбөргүй хүлээн авсаныг үндсэн хөрөнгөнд орлогоор бүртгэн 688,369.1 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Тайлант онд Нийгмийн даатгалын шимтгэлийн дутуу төлөлт 1,015.9 мянган төгрөг, ХХОАТ-ын 147,1 мянган төгрөгийг өглөгийг тайланд нэмж тусгасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 786,944.3 мянган төгрөгөөр нэмэгдэж 2,500,603.1 мянган төгрөг болсон байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс өөрчлөлтгүй, тайлант үеийн үр дүн 788,136.3 мянган төгрөгөөр нэмэгдэж 2,501,795.1 мянган төгрөг болсон байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,911,525.1 мянган, орон нутгаас авах санхүүжилтийг 146,573.0 мянган төгрөг нийт санхүүжилт 2,058,098.1 мянган төгрөгөөр төлөвлөж тодотгосон байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802 (Ерөнхий боловсрол) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс баталсан 1,976,014.2 мянган төгрөгийн санхүүжилтийг авч өмнөх оны харилцах дансны үлдэгдлээс 118,579.2 мянга, орон нутгийн төсвөөс 146,573.0 мянган төгрөг нийт мянган төгрөгийн эх үүсвэртэй гүйцэтгэлээр 1,850,159.5 мянган төгрөгийг зарцуулж, 243,075.4 мянган төгрөг харилцах дансанд үлдэгдлээр зарцуулагдаагүй байна.

Орон нутгийн төсвөөс олгохоор баталсан 146,576.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр батлагдсан санхүүжилтийн 99 хувь буюу 145,214.5 мянган төгрөгийг зарцуулж 1,358.5 мянган төгрөгийн буцаан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| № | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 80226 Байр ашиглалтын үйлчилгээ | 3,243.1 | 3,235.9 | 7.2 | 99.7% |
| 2 | 80233 Хүүхэд хамгаалал | 3,348.0 | 3,348.0 | | 100% |
| 3 | 80312 Сургалт семинар | 2,278.7 | 2,280.3 | -1.6 | 100% |
| 4 | 81605 Эрүүл мэндийг дэмжих | 3,243.1 | 4,845.2 | -1602.1 | 149% |
| 5 | 81801 Үдийн цай хөтөлбөр | 56,858.2 | 64,224.5 | -7,366.3 | 112.9% |
| 6 | 81806 Дотуур байр | 321,283.4 | 275,589.9 | 45,693.5 | 85.7% |
| 7 | 81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 30,834.0 | 30,832.9 | 1.1 | 99.9% |
| 8 | 81823 Боловсролын байгууллагын багш | 9,730.8 | 4,319.2 | 5,411.6 | 44.3% |
| 9 | 81827 Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр | 11,039.1 | 9,273.7 | 1,765.4 | 84% |
| 10 | 81834 Боловсролын стандарт, сургалтын | 1,273,130.0 | 1,201,641.5 | 71,488.5 | 94.3% |
| 11 | 81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 106,944.0 | 99,157.2 | 7,786.8 | 92.7% |
| 12 | 81875 Сургуулийн нэмэлт хөтөлбөр | 5,616.0 | 4,580.8 | 1,035.2 | 81.5% |
| 13 | 81844 Гүнгзгийрүүлсэн болон төрөлж | 2,073.6 | 1,880.0 | 193.6 | 90.6% |
| 14 | 80112 Нийтлэг үйлчилгээ | 146,573.0 | 145,214.4 | 1358.6 | 99% |
| 15 | 2023 оны харилцахын үлдэгдэлээс | | 118,579.2 | 118,579.2 | |
| | ДҮН | 1,979,447.3 | 1,850,159.5 | 129,287.8 | 93.4% |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Эх сурвалж:2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Баянговь сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Номгон аудит ХХК-ийн захирал, аудитор Г.Саранчимэг гүйцэтгэж, хяналтыг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын менежер М.Алтантуяа, Баянхонгор аймгийн газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянговь сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитад шаардлагатай баримт материалыг Номгон Аудит ХХК-д 2025 оны 1 дүгээр сарын 24-ны өдөр ирүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг сургуулийн захирал Ц.Буянтогтох 2024.01.01-2024.08,28 хүртэл, захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, сургуулийн менежер Р.Саруул 2024.09.01-2024.12.31 хүртэл хугацаагаар 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Ж.Золжаргал нар зурж, нярваар Х.Батбаяр нар ажиллажээ.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны анхны батлагдсан төсөв 2,102,387.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 21,023.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 15,767.9 мянган төгрөгөөр тогтоосон.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,976,195.0 мянган төгрөгийн 96 гүйлгээ, зарлагын 304,915.9 мянган төгрөгийн 55 гүйлгээг хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

| д/д | Хугацаа | Төрөл | Мэдээлвэл зохих/удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 5 | 5 | 5 | | 0 |
| 2 | Хагас жил | 2 | 2 | 2 | | |
| 3 | Сар бүр | 2 | 24 | 24 | 0 | |
| 4 | Тухай бүр | 7 | 84 | 84 | 0 | |
| | Нийт | 16 | 115 | 115 | | 0 |

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *нийцсэн* гэж дүгнэлээ.

### 4.5 Худалдан авах ажиллагааны талаар

Тус сургууль нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа, ажил үйлчилгээ худалдан авах үнэлгээний хороог захирлын 2024 оны 01 дүгээр сарын 5-ны өдрийн А/03 дугаар тушаалаар 3 хүний бүрэлдхүүнтэй томилж дотуур байрны хүүхдийн хоол 64,224.5 мянга, үдийн хоолны 77,646.6 мянган төгрөгийн материал нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерыг харьцуулалтын аргаар зохион байгуулахаар 2024 оны 2 дугаар сарын 02-ны өдрөөс 02 дугаар сарын 15-ний өдрийг хүртэл худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-;-д тендерийн бичиг баримтыг байршуулсан байна.

Үдийн хоолны материал нийлүүлэх тендерт 64,224.5 мянган төгрөг, дотуур байрны хүүхдийн хоолны материал нийлүүлэх тендерт 77646.6 мянган төгрөгийн тендерт “Мөнхөд дэлгэрэх” ХХК бараа материал нийлүүлэх гэрээг 2024 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31 хүртэл хугацаанд байгуулан ажилласан байна. Худалдан авах гэрээний үнийн дүнг мөрдөн ажиллаж гэрээг дүгнэн ажилласан байна.

### 4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.6.1 Завсрын аудитын талаар

*Завсрын аудит хийгдээгүй болно.*

#### 4.6.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянташаагийн эх аудит ХХК -ний аудитын баг гүйцэтгэж өөрчлөлтгүй дүгнэлт өгч ажилласан байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын урамшууллыг олгохдоо “Өөрчлөлтгүй” гэж дүгнэгдсэн ба нягтлан бодогч үндсэн цалингийн 3 сартай тэнцэх хэмжээний урамшуулал олгох тушаал гарган олгосон байна. Иймд дараагийн аудитаар дээрх урамшууллыг хавтгайруулан олгосон эсэх асуудлыг авч үзэх шаардлагатай.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 79,069.4 мянган төгрөгийн 3 зөрчил илэрч 76,551.1 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 2,518.3 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоов.

### 5.1.1 Албан шаардлага

Байгууллагын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн бараа материал бүлгийн тусгай зориулалтын материал, бичиг хэргийн материал, аж ахуйн материал, түлш шатахуун, барилгын засварын материал, бусад хангамж дансны 2024 оны 07 дугаар сарын 01-нээс 12 дугаар сарын 31 дуустлах анхан шатны баримт, тайлан ирүүлээгүйгээс бараа материалын тайлан дах орлогын 44.512.0 мянган төгрөг зарлагын 32.039.1 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлийг тус тус нотлох боломжгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дэх "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.6 дэх "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" үнэн зөв байх, бодитой оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

**Шийдвэрлэсэн нь**: Боловсрол Ерөнхий газрын дотоод хяналтын нэгжээр шалгуулж, зөрчлийг арилгах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Боловсрол газрын дарга Ж.Алтанцэцэгт албан шаардлага хүргүүлэх.

### 5.1.2 Төлбөрийн акт

1. Тус байгууллагын нягтлан бодогч нь тайлант оны 6.7.8 дугаар сарuudад НДШ-ийн тайланг 5,099,256.00(Таван сая ерэн есөн мянга хоёр зуун тавин зургаан) төгрөгөөр зөрүүтэй мэдээлснээс ажил олгогч даатгуулагч 4 иргэний НДШ–ийн 1,015,930.28 (Нэг сая арван таван мянга есөн зуун гучин төгрөг 28 мөнгө)төгрөгийг мэдээлээгүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх " ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд ногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж хугацаанд нь төлөх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1."Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно",гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь** НДШ-ийн тайланг нөхөн мэдээлж төлбөрийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь Нийгмийн даатгалын хэлтсийн 100030090000 тоот дансанд төлүүлэхээр төлбөрийг акт тогтоов.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

2. Тайланд онд албан хаагчдын цалингаас суутган тооцсон ХХОАТ-ыг Баянговь сумын Татварын албатай тооцоо нийлээгүйгээс 147,100.00 (Нэг зуун дөчин долоон мянга нэг зуун) төгрөгийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй, захирлын 2024 оны 11 дүгээр сарын 18 өдрийн Б/47 "Гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулал олгох тухай" тушаалаар олгосон 27,106.0 мянган төгрөгийн урамшуулалаас ХХОАТ -ыг 5 % суутгаж хувь хэмжээг бууруулсанаас 1,355,300.00 (Нэг сая гурван зуун тавин таван мянга гурван зуун) төгрөгийг дутуу суутгасан байна

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т “Дансны өглөг авлага ба төлбөр тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас өмнө хянан баталгаажуулах, 20.2.7-т “Аж ахуйн нэгж байгууллагын татвар төлбөр хураамж шимтгэлийн тооцоололыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийг үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь** Төсвийн шууд захирагч, нягтлан бодогчоор төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

## 6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн алдааны нэгтгэл

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлантай холбоотой зөрчил | | | | | | | | |
| Байгууллагын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн бараа материал бүлгийн тусгай зориулалтын материал, бичиг хэргийн материал, аж ахуйн материал, түлш шатахуун, барилгын засварын материал, бусад хангамж дансны сүүлийн хагас жилийн анхан шатны баримт, тайлан ирүүлээгүйгээс бараа материалын тайлан дах орлогын 44.512.0 мянган төгрөг зарлагын 32.039.1 мянган төгрөгийн бараа материалын гүйлгээг тус тус нотлох боломжгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4, 20.2.6 дэх заалтуудыг зөрчсөн байна | 1 | 76,551.1 | | | 1 | 76,551.1 | | |
| Тус байгууллагын нягтлан бодогч нь тайлант оны 6.7.8 дугаар саруудад НДШ-ийн тайланг 5,099,2 мянган төгрөгөөр зөрүүтэй мэдээлснээс ажил олгогч даатгуулагч 4 иргэний НДШ–ийн 1,015,9 мянган төгрөгийг мэдээлээгүй нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх ,Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх заалтуудыг зөрчсөн байна | 1 | 1,015.9 | 1 | 1,015.9 | | | | |
| Тайланд онд албан хаагчдын цалингаас | 1 | 1502.4 | 1 | 1502.4 | | | | |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| суутган тооцсон ХХОАТ-ыг Баянговь сумын Татварын албатай тооцоо нийлээгүйгээс 147,1 мянган төгрөгийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй, мөн Захирлын 2024 оны 11 дүгээр сарын 18 өдрийн Б/47 "Гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулал олгох тухай" тушаалаар олгосон 27,106.0 мянган төгрөгийн урамшуулалаас ХХОАТ -ыг 5 % суутгаж хувь хэмжээг бууруулсанаас 1,355.3 мянган төгрөгийг дутуу суутгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5, 20.2.7, 14.4.2 дах заалтуудыг зөрчсөн байна. | | | | | | | | |
| Нийт дүн | 3 | 79,069.4 | 2 | 2,518.3 | 1 | 76,551.1 | | |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

--oOo---



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 54/1H210513/БНА-2025/019/ НА-СТА-ТШ3 Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянговь сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын нягтлан бодогч нь тайлант оны 6.7.8 дугаар саруудад нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд цалинг 5,099,256.00(Таван сая ерэн есөн мянга хоёр зуун тавин зургаан) төгрөгөөр зөрүүтэй мэдээлснээс ажил олгогч даатгуулагч 4 иргэний нийгмийн даатгалын шимтгэлийн 1,015,930.28 (Нэг сая арван таван мянга есөн зуун гучин төгрөг 28 мөнгө)төгрөгийг мэдээлээгүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх " ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд ногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж хугацаанд нь төлөх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1."Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно",гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.4 дахь "Төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

5050109

1. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээ тайланг хугацаанд нь үнэн зөв мэдээлээгүйгээс 1,015,930.28 (Нэг сая арван таван мянга есөн зуун гучин төгрөг 28 мөнгө) төгрөгийг нөхөн мэдээлж төлбөрийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь Нийгмийн даатгалын хэлтсийн 100030090000 тоот дансанд төлүүлэхээр төлбөрийг акт тогтоов.

2.Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2025 оны 05 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянговь сумын ерөнхий боловсролын сургуулийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Уранчимэг, нягтлан бодогч Ж. Золжаргал нарт хариуцуулав[1].

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН[2]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ, АУДИТОР: Г.САРАНЧИМЭГ

[1] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[2] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 55/14210513/БНА-2025/019/НА-СТА-ТШЗ Номгон

## Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянговь сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайланд онд албан хаагчдын цалингаас суутган тооцсон ХХОАТ-ыг Баянговь сумын Татварын албатай тооцоо нийлээгүйгээс 147,100.00 (Нэг зуун дөчин долоон мянга нэг зуун) төгрөгийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй, мөн Захирлын 2024 оны 11 дүгээр сарын 18 өдрийн Б/47 "Гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулал олгох тухай" тушаалаар олгосон 27,106.000 төгрөгийн урамшууллаас ХХОАТ -ыг 5 % суутгаж хувь хэмжээг бууруулснаас 1,355,300 (Нэг сая гурван зуун тавин таван мянга гурван зуун) төгрөгийг дутуу суутгасан байна

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т “Дансны өглөг авлага ба төлбөр тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас өмнө хянан баталгаажуулах, 20.2.7-т “Аж ахуйн нэгж байгууллагын татвар төлбөр хураамж шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийг үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна..

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.6 дахь

5050114

"Эрх бүхий этгээд тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Суутган тооцоогүй ХХОАТ 1,502,400.00 /Нэг сая таван зуун хоёр мянга дөрвөн зуун/ төгрөгийг төсвийн захирагч, нягтлан бодогч нараар төлүүлж Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2.Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2025 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ирүүлэхийг Баянговь сумын ерөнхий боловсролын сургуулийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Уранчимэг, нягтлан бодогч Ж.Золжаргал нарт хариуцуулав[1].

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН[2]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ, АУДИТОР: Г.САРАНЧИМЭГ

[1] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[2] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 127/14210513/БНА-2025/019/ Номгон
НА-СТА-ТШ3

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянговь сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн бараа материал бүлгийн тусгай зориулалтын материал, бичиг хэргийн материал, аж ахуйн материал, түлш шатахуун, барилгын засварын материал, бусад хангамж дансны 2024 оны 07 дугаар сарын 01-нээс 12 дугаар сарын 31 дуустлах анхан шатны баримт, тайлан ирүүлээгүйгээс бараа материалын тайлан дах орлогын 44,512.0 мянган төгрөг, зарлагын 32,039.1 мянган төгрөгийн бараа материалын гүйлгээг тус тус нотлох боломжгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дэх "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.6 дэх "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" үнэн зөв байх, бодитой оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар

5040254

тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дахь “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Баянговь сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланд анхан шатны баримтаар нотлогдохгүй байгаа бараа материалын бүлэг дансны сүүлчийн хагас жилийн баримтуудыг Баянхонгор аймгийн Боловсролын газрын дотоод хяналтын нэгжээр шалгуулж, зөрчлийг арилган биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх[1]

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын дарга Ж.Алтанцэцэгт даалгав[2].

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН[3]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ, АУДИТОР: Г.САРАНЧИМЭГ

[1] Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

[2] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

[3] Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно